Golomt Capital®

ТАВААРЫН ЗАХ ЗЭЭЛИЙН ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

Алт
Нүүрс
Төмрийн хүдэр
Зэс
Газрын тос

Голомт Капитал ҮЦК ХХК-д бэлтгэв

2022.05.09

Golomt Capital®

АЛТНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 09

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал

Өнгөрөгч 7 хоногт алтны ханш 0.7%-иар унав. Ам.долларын ханш чангарч байгаа нь алтны ханшийг унагах гол шалтгаан болж байна.

Тодруулбал, АНУ-ын төв банкнаас хэрэгжүүлж буй мөнгөний хатуу бодлогын хүрээнд бондын өгөөж нэмэгдэж ам.долларын ханш сүүлийн хоёр жил дэх хамгийн өндөр түвшинд байна.

Энэ нь хөрөнгө оруулагчдад ямар ч хүүгүй алтнаас илүүтэйгүүр өндөр хүүтэй бондод хөрөнгө оруулахад хүргэж байна.

БНХАУ-д хөл хорио удаан үргэлжилбэл эдийн засгийн хэтийн төлөв улам муудаж, богино хугацаанд шар металын эрэлт багасч магадгүй гэсэн болгоомжлол бий.

Өнгөрсөн баасан гарагт АНУ-ын фирмийн бус ажил эрхлэлтийн тайлан сайн гарснаар бодлогын хүүг эрчимтэй нэмэх нөхцөл бүрдэж байна хэмээн шинжээчид үзэж байна.

Алтыг инфляцийн өсөлт, тодорхойгүй байдлаас хамгаалах хэрэгсэл гэж үздэг ч хүүгийн түвшин нэмэгдэж байгаа нь хүүгүй активыг эзэмших зардлыг нэмэгдүүлснээр хөрөнгө оруулах сонирхлыг бууруулж байна.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*

Golomt Capital®

ГАЗРЫН ТОСНЫ ДОЛОО ХОНОГИЙН ТОЙМ

2022 оны 5-р сарын 09

Өнгөрсөн ба энэ долоо хоногийн онцлох үйл явдал:

Европын холбооноос ОХУ-д нефтийн хориг тавьж, дэлхийн газрын тосны нийлүүлэлтийг чангатгах төлөвтэй байгаа тул өнөөдөр Азийн зах зээлд газрын тосны ханш уналттай нээгдлээ.

Брент маркийн нефт 67 цент буюу 0.6%-иар буурч, баррель нь 111.72 ам.доллар болсон бол АНУ-ын баруун Техасын газрын тос 75 цент буюу 0.7%-иар буурч 109.02 ам.доллар болжээ.

ОПЕК+ ирэх сард олборлолтоо нэмэхгүйгээр шийдсэн нь Европын Холбоог хүнд байдалд оруулаа. Учир нь ОХУ-ын хоригт орсон баррель тосыг орлох нэмэлт нефть Европ руу ирэхгүй гэсэн үг юм. Европын Комисс энэ 7 хоногийн эхээр Оросын түүхий нефть болон боловсруулсан бүтээгдэхүүнд хориг тавихыг санал болгов.

ЕХ-ны ерөнхийлөгч Урсуал фон дер Лейен түүхий газрын тосны хориг зургаан сарын дараа, боловсруулсан бүтээгдэхүүний хориг оны эцсээр хүчин төгөлдөр болно гэж мэдэгдэв. Тэгэхээр ЕХ-ны орнуудад өөр нийлүүлэгч олох 6 сарын хугацаа үлдэж байна.

Европын холбоо ОХУ-аас 3.5 сая баррель түүхий тос, боловсруулсан бүтээгдэхүүн импортолдог. Энэ нь Оросын нийт газрын тос, бүтээгдэхүүний экспортын тал орчим, ЕХ-ны нефтийн импортын дөрөвний нэг орчим хувь юм.

Гуравдугаар сард ОПЕК-ийн Ерөнхий нарийн бичгийн дарга Мохаммед Баркиндо Оросын нефтийн экспортод тавьсан хоригийг бүрэн хэмжээгээр нөхөх нөөц хүчин чадал дэлхийд байхгүй гэж анхааруулсан бөгөөд энэ нь өдөрт 7 сая баррель түүхий болон боловсруулсан бүтээгдэхүүн юм.

ЕХ нь 6 сарын хугацаанд шийдэл олж чадахгүй бол бензин, дизель түлш болон дотоод шаталтат хөдөлгүүртэй тээврийн хэрэгслээр тээвэрлэгддэг бүх зүйл төсөөлж байснаас удаан хугацаанд унэтэй байх болно.

Мэдэгдэл: *Энэхүү судалгаанд дурьдагдсан аливаа таамаглал нь зөвхөн мэдээллийн зорилготой бөгөөд аливаа хөрөнгө оруулалт, арилжаа хийхийг ятгасан, санал болгосон үйлдэл биш болно. Энэхүү судалгаанд дурьдагдсан таамаглалаас үүдэн гарах аливаа эрсдэлийг шинжээчи болон компани хариуцахгүй болно. Энэхүү тойм, судалгаа, таамаглалыг зөвхөн өөртөө зориулан ашиглаж, бусдад түгээн олшруулахыг хатуу хориглоно.*